

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ 2-Р САРЫН
АЖЛЫН ТАЙЛАН

2020 оны 3 дугаар сар 03

Жаргалант

Үйл ажиллагааны талаар

Сумын ИТХ-ын төлөөлөгч, сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, багийн Засаг дарга зэрэг 28 албан тушаалтнаас 2019 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар авч холбогдох тайлангуудыг гарган баталгаажуулж архивын нэгж болгон үдсэн.

Сумын ИТХ-ын 2017, 2018, 2019 оны тогтоолуудыг скайнердан цахим архив үүсгэсэн.

Сумын ИТХ-ын албан ёсны цахим хуудас болох Jargalant.tov.khural.mn сайтанд мэдээ мэдээлэл нэмж ажиллахын зэрэгцээ Shilendans.gov.mn сайтад шилэн дансны мэдээллийг хугацаанд нь шинэчлэн ажилласан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн төслийг үлгэрчилсэн дүрмийн дагуу боловсруулан Тэргүүлэгчдийн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг хийлгэж төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр эрүүл мэндийн төвийн 15 албан хаагч, Өгөөмөр цэцэрлэгийг 12 албан хаагч нийт 27 албан хаагчид 12 хуулиар сургалт зохион байгуулж гарын авлага, нугалбар тараасан. Суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний цэг салбар, төсөвт байгууллагуудад корона вирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж байршуулж, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа, тарааж тамхи болон согтууруулах ундаа борлуулах тусгай зөвшөөрөлд шалгалт хийж тохирлын гэрчилгээ сунгагдаагүй 1, тамхи зарах зөвшөөрөлгүй 2 дэлгүүр илрүүлэн гэрчилгээ болон худалдаалж байсан тамхи зэргийг хурааж битүүмжлэн ажилласан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх амьжиргааг дэмжих зөвлөлийн хуралдааныг 2-р сард 2 удаа хийж 2 иргэнд асаргаа тогтоох, асаргаа тогтоох ажлын хэсэг томилох, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 113 өрхүүдэд өөрчлөлт оруулах санал авах, тухай орхийн гишүүдийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн гэх асуудлуудыг хэлэлцсэн.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэдээллийн самбарыг шинэчлэн мэдээллээр баяжуулан ажиллав.

Санхүүгийн анхан шатны баримтын шалгалтанд хамрагдаж эрсдлийн үнэлгээгээр 93 хувь буюу бага эрсдэлтэй, анхан шатны бүртгэл хөтлөлт 91,9 хувь буюу шаардлагын түвшинд, зөрчилгүй гэсэн дүгнэлт авч шалгуулсан.

Ковид-19 халдвартай холбоотой өндөржүүлсэн бэлэн байдал зарласан, хөл хорио тогтоосонтой холбоотой сар шинийн баярын өдрүүдэд эргүүл жижүүрээр ажилласан.

Төв түмний мэнд теле нэвтрүүлэгт ИТХ-ын дарга оролцсон.

Хуралдааны талаар

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг 1 удаа хийж нийт 9 асуудал хэлэлцэн шийдвэрлэж 6-н тогтоол гаргаж ажиллав. Уг хуралдаануудын тогтоол тэмдэглэлийг албажуулан ажилласан.

Хэлэлцсэн асуудлууд:

1. Уриан жилийн ажлын төлөвлөгөө
2. Сумын 2019 оны төсвийн гүйцэтгэлийг батламжлах тухай /анхны хэлэлцүүлэг/
3. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2019 оны тайлан мэдээлэл
4. Эхийн алдар одонгоор шагнуулахаар нэр дэвшүүлэх тухай
5. Төрийн одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэх тухай
6. Сонгуулийн хэсэг байгуулах тухай
7. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тов тогтоох тухай
8. ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах, ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг томилох тухай
9. ИТХ-ын даргад нэг удаагийн мөнгөн тусламж олгох тухай

Өргөдөл, гомдол, хүсэлт болон албан бичиг, хэргийн шийдвэрлэлтийн байдлын талаар:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд болон ИТХ-ын даргад 2020 оны 02 дугаар сард нийт-2, үүнээс хариутай-2 албан бичиг ирсэн.

Шийдвэрлэсэн албан бичиг-2 үүнээс хариутай-2 хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй байна.

Сумын ИТХ-аас нийт 2 албан бичгийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэнд явуулсан байна.

Тайлант хугацаанд өргөдөл хүсэлт ирээгүй байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  ЦАГАНПҮРЭВ

ТАНИЛЦСАН:

ИТХ-ЫН ДАРГА  Д.УРАНЧИМЭГ